



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2026/5/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70373089 Цахим хаяг: Altanzulby@audit.gov.mn

Аудитор Ч.Болормаа

Утас: 70373089 Цахим хаяг: Bolormaach@audit.gov.mn

Аудитор Г.Золбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: Zolbayarg@audit.gov.mn



Дархан-Уул аймаг

2026 он



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.12 № 173

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2025 онд 2,458.8 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал ачуулж, 28.43 мянган тонн ган цувимал бүтээгдэхүүнийг борлуулснаар нийт 585,813.6 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 72,182.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилссанаар цэвэр ашгийн төлөвлөгөө 142.0 хувиар биелсэн байна.

Дархан терминалаас 2025 онд нийт 1,453.5 мянган тонн төмрийн хүдэр экспортолсон нь өмнөх оноос 220 хувиар, Төмөртэй терминалаас нийт 1,003.1 мянган тонн төмрийн хүдэр экспортолсон нь өмнөх оноос 260 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан 135 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол нэгдэлд ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, экспортыг нэмэгдүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, гадаад валютын нөөцийг 1 тэрбум ам.доллаар нэмэгдүүлэх чиглэл өгсөн байна. Үүнээс “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2025 оны төлөвлөсөн орлогоос гадна нэмэлтээр 117.0 сая ам.долларын орлогыг Монгол Улсын валютын санд төвлөрүүлэх үүрэг хүлээснээс 127.4 сая ам.долларыг төвлөрүүлж хүлээсэн үүргээ давуулсан биелүүлсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

452050296

Тайлант онд Монголын хөрөнгийн биржээр нийт 56 удаагийн арилжааг амжилттай зохион байгуулж 3,643.5 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал борлуулах гэрээг байгуулж ажилласан байна.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2024 онд жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1,217.59 төгрөгийн ногдол ашиг зарлаж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу “Эрдэнэс монгол” ХХК-д 25,998.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2025 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 693 дугаар үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай тогтоол, 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 577 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 5,381.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, мөн 2024 онд дуудлага худалдаагаар борлуулагдаагүй 379.6 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 841 дүгээр тогтоолыг үндэслэн акталж данснаас хассан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 522 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам болон “Кью Эс Си” ХХК-ийн хооронд байгуулсан концессын гэрээний хүрээнд бий болсон Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Хандгайт өртөөнөөс Төмөртэйн орд хүртэлх төмөр зам, ачиж буулгах терминалын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор эзэмшигч, ашиглагчаар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийг тогтоосонтой холбогдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 1,634 байхаар өөрчилсөн байна.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	52,122,935,268.06	108,529,508,774.90
1.1.2	Дансны авлага	11,055,871,614.31	7,840,103,827.30
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,002,417,486.06	2,346,475,293.35
1.1.4	Бусад авлага	616,152,307,534.25	609,773,015,919.27
1.1.6	Бараа материал	386,527,855,986.30	411,089,882,469.81
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	15,719,903,099.70	9,975,806,667.32
1.1.8	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	791,521,792.77
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,083,581,290,988.68	1,150,346,314,744.72
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	133,675,239,294.27	140,955,127,551.42
1.2.2	Биет бус хөрөнгө	42,830,977,262.92	42,744,837,499.99
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	3,375,149,249.09	3,375,149,249.09
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,617,689,996.28	4,478,596,032.64
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	182,499,055,802.56	191,553,710,333.14
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,266,080,346,791.24	1,341,900,025,077.86
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	50,666,376,932.21	59,120,462,996.06
2.1.1.2	Цалингийн өглөг	2,904,198,254.00	3,787,452,104.55
2.1.1.3	Татварын өр	408,415,705,518.65	265,578,569,806.75
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	42,365,878,005.62	40,466,915,581.62
2.1.1.6	Хүүний өглөг	30,610,868,010.18	30,610,868,010.18
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	244,125,067,477.05	412,781,655,248.35
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	2,956,060,227.94	1,717,259,137.05
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	6,292,121,179.54	5,117,567,050.95
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	788,336,275,605.19	819,180,749,935.51
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	101,105,797,552.13	101,105,082,874.13
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	13,750,786,813.55	13,750,786,813.55
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	64,683,452,175.90	64,683,452,175.90
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	179,540,036,541.58	179,539,321,863.58
2.2	Өр төлбөрийн нийт дүн	967,876,312,146.77	998,720,071,799.09
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	21,353,312,476.16	21,353,312,476.16
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	56,497,325,605.99	56,497,325,605.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	220,353,396,562.32	265,329,315,196.62
2.3.11	Эздийн өмчийн дүн	298,204,034,644.47	343,179,953,278.77
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,266,080,346,791.24	1,341,900,025,077.86



2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	291,738,823,201.16	585,813,688,053.40
2	Борлуулалтын өртөг	124,977,864,329.72	268,838,679,537.40
3	Нийт ашиг (алдагдал)	166,760,958,871.44	316,975,008,516.00
4	Түрээсийн орлого	429,858,880.03	473,211,403.64
5	Хүүгийн орлого	410,483,661.10	1,942,679,204.88
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,159,218,818.39	4,871,868,307.54
9	Борлуулалт, маркетингийн зардал	85,927,104,309.25	199,894,062,783.66
10	Ерөнхий ба удирдлагын зардал	13,751,255,781.46	26,323,493,647.65
11	Санхүүгийн зардал	733,007,551.09	-
12	Бусад зардал	815,949,589.61	7,779,018,142.70
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	173,745,382.28	3,938,024,110.74
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(6,291,082.37)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	3,306,080,892.39	36,120,779.31
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	71,013,029,274.22	94,234,046,665.73
19	Орлогын татварын зардал	19,016,469,225.55	22,051,827,874.89
20	Татварын дараах ашиг (алдагдал)	51,996,560,048.67	72,182,218,790.84
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	51,996,560,048.67	72,182,218,790.84
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-




2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлт

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,353,312,476.16	0.00	0.00	0.00	0.00	0.00	184,554,419,722.57	205,907,732,198.73
2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(2,582,622,694.21)	(2,582,622,694.21)
3 Залруулсан үлдэгдэл	21,353,312,476.16	0.00	0.00	0.00	0.00	0.00	181,971,797,028.36	203,325,109,504.52
4 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	51,996,560,048.67	51,996,560,048.67
5 Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6 Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7 Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(13,614,960,514.71)	(13,614,960,514.71)
8 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	56,497,325,605.99	0.00	0.00	0.00	56,497,325,605.99
9 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,353,312,476.16	0.00	0.00	56,497,325,605.99	0.00	0.00	220,353,396,562.32	298,204,034,644.47
10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(1,208,020,132.20)	(1,208,020,132.20)
11 Залруулсан үлдэгдэл	21,353,312,476.16	0.00	0.00	56,497,325,605.99	0.00	0.00	219,145,376,430.12	296,996,014,512.27
12 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	72,182,218,790.84	72,182,218,790.84
13 Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14 Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15 Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(25,998,280,024.34)	(25,998,280,024.34)
16 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,353,312,476.16	0.00	0.00	56,497,325,605.99	0.00	0.00	265,329,315,196.62	343,179,953,278.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	361,930,725,216.59	780,292,134,478.55
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	359,204,538,642.56	779,159,903,106.67
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,726,186,574.03	1,132,231,371.88
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(301,601,057,659.14)	(683,625,762,634.80)
1.2.1	Ажиллагсадад төлсөн	(58,305,840,515.07)	(82,433,017,776.17)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(17,261,227,453.49)	(24,381,417,209.42)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(36,462,676,732.96)	(35,834,372,329.98)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(9,857,654,837.73)	(9,891,525,841.19)
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(103,119,528,410.11)	(268,419,089,276.45)
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	(693,768,363.01)	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(38,334,918,295.65)	(222,239,807,068.73)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(60,500,000.00)	(17,763,975.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(37,504,943,051.12)	(40,408,769,157.86)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	60,329,667,557.45	96,666,371,843.75
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	410,483,661.10	1,949,679,204.88
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	7,000,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	410,483,661.10	1,942,679,204.88
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(3,572,318,772.20)	(17,954,417,079.73)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(3,379,882,687.00)	(17,947,003,079.73)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(192,436,085.20)	(7,414,000.00)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,161,835,111.10)	(16,004,737,874.85)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(18,616,227,661.56)	(27,897,957,126.34)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(5,001,267,146.86)	(1,899,677,102.00)
3.2.4	Төлсөн ногдол ашиг	(13,614,960,514.70)	(25,998,280,024.34)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(18,616,227,661.56)	(27,897,957,126.34)
4	Валютын ханшийн зөрүү	613,714,208.28	3,642,896,664.28
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	39,165,318,993.07	56,406,573,506.84
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,957,616,274.99	52,122,935,268.06
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,122,935,268.06	108,529,508,774.90



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны			
				Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
1.1	Круг үйлдвэрлэлт	мян.тн	28.6	26.0	27.4	1.4	105%
1.2	Арматур үйлдвэрлэлт	мян.тн	6.4	7.0	6.1	(0.9)	88%
1.3	Төмрийн хуурай баяжмал Fe 55-58%	мян.тн	1,744.5	1,420.4	1,830.1	409.6	129%
1.4	Төмрийн хуурай баяжмал Fe 40-54%	мян.тн	448.5	542.3	549.1	6.9	101%
2	Бүтээгдэхүүн борлуулалт						
2.1	Круг борлуулалт	мян.тн	23.74	26.57	26.78	0.21	101%
2.2	Арматур борлуулалт	мян.тн	2.20	10.11	1.65	(8.46)	16%
2.3	Экспортын баяжмал борлуулалт	мян.тн	1,026.70	2,097.9	2,419.2	321.32	115%
2.4	Дотоодын баяжмал борлуулалт	мян.тн	29.20	50.0	39.6	(10.43)	
3	Уулын ажил						
3.1	Уулын цул	мян.м3	3,150.1	3,294.4	3,414.7	120.4	104%
3.2	Хөрс хуулалт	мян.м3	2,547.7	2,440.2	2,523.6	83.4	103%
3.3	Төмрийн хүдэр олборлолт	мян.тн	2,466.3	3,543.8	3,744.3	200.5	106%
3.4	Хөрс хуулалтын дундаж коэффициент	харьцаа	1.03	0.69	0.67	(0.01)	98%
4	Хүдэр боловсруулалт						
4.1	Төмрийн хүдэр	мян.тн	2,565.8	2,467.4	2,717.0	249.6	110%
5	Нийт орлого	мян.төг	291,738,823.2	551,643,988	593,101,447	41,457,459	108%
5.1	Үйл ажиллагааны орлого	мян.төг	291,525,130.0	550,922,523	585,813,688	34,891,166	106%
5.1.1	Экспортын баяжмал борлуулалт	мян.төг	205,380,548.8	434,744,598	488,066,276	53,321,678	112%
5.1.2	Дотоодын баяжмал борлуулалт	мян.төг	1,149,380.1	3,924,960	3,769,748	(155,212)	96%
5.1.3	Круг борлуулалт	мян.төг	79,954,396.0	89,564,232	90,266,259	702,027	101%
5.1.4	Арматур борлуулалт	мян.төг	5,040,805.0	22,688,733	3,711,405	(18,977,328)	16%
5.2	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	213,693.2	721,466	7,287,759	6,566,293	1010%
6	Нийт зардал	мян.төг	298,878,906.6	504,585,804	504,133,755	(452,050)	100%
6.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	124,978,015.7	263,280,976	268,838,680	5,557,704	102%
6.2	Борлуулалт, маркетингийн зардал	мян.төг	85,927,104.3	189,405,487	199,894,063	10,488,576	106%
6.3	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	14,484,102.0	29,476,298	26,323,494	(3,152,804)	89%
6.4	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	-	5,715,225	7,779,018	2,063,793	136%
7	Шилжих өртөг	мян.төг	73,489,684.6	16,707,819	65,809	(16,642,011)	0%
	Үйл ажиллагааны бус ашиг	мян.төг	4,663,428.1	-	3,967,854	3,967,854	
8	Татварын өмнөх ашиг	мян.төг	71,013,029.3	63,766,002	94,234,047	30,468,045	148%
9	Цэвэр ашиг	мян.төг	51,996,560.0	50,893,842	72,182,219	21,288,377	142%
10	Төсөвт төлөх татвар, шимтгэл	мян.төг	72,834,205.4	82,108,966	246,621,224	164,512,258	300%
10.1	ААНОАТ	мян.төг	19,016,469.2	12,872,160	65,709,837	52,837,676	510%
10.2	НӨАТ	мян.төг	857,070.8	5,933,403	24,326,615	18,393,212	410%
10.3	АМНАТ	мян.төг	27,927,955.2	27,904,994	113,951,040	86,046,046	408%
10.4	Бусад	мян.төг	25,032,710.2	38,413,613	42,633,733	4,220,120	111%
11	Ногдол ашиг	мян.төг	13,614,960.5	25,998,280	25,998,280	-	100%
12	Ажиллагсдын тоо	хүн	1,490	1,634	1,563	(71)	96%
13	Цалингийн сан	мян.төг	70,500,809.7	99,992,456.1	99,621,894.2	(370,562)	100%
14	Ажиллагсдын сарын дундаж цалин	төгрөг	3,942,998	5,099,574	5,310,619	211,044	104%
15	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.84	0.91	0.89	(0.02)	98%
16	Борлуулсан бүтээгдэхүүний нэгж өртөг	төг/тн					
16.1	Ган бүтээгдэхүүний өртөг	төг/тн	2,738,178	2,907,224	2,890,291	(16,933)	99%
16.2	Төмрийн хуурай баяжмал Fe 58	төг/тн	194,240	204,402	173,928	(30,474)	85%
17	Хөрөнгө оруулалт	мян.төг	16,773,070.5	59,968,656	20,109,265	(39,859,391)	34%
18	Нийт авлага	мян.төг	644,930,499.7	602,752,751	619,959,595	17,206,844	103%
19	Нийт өглөг	мян.төг	967,876,312.1	845,137,401	998,720,072	153,582,671	118%
20	Ханшийн төсөөлөл	төгрөг	3,417.8	3,536	3,431	(105.3)	97%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Зөвлөмж

3.1.1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчин нэг удаагийн нөхөн дүүргэлтийн хэмжээг хэтрүүлэн 4 удаагийн 115.0 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийсэн байна. Энэ нь гүйцэтгэх захирлын 2024 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын 2.2.1-т “Компанийн кассын нэг сарын санхүүжилт, нэг удаагийн нөхөн дүүргэлтийн дүн 10,000,000 /арван сая төгрөгөөс хэтрэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг баримтлан ажиллах.

3.1.2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 14,197.9 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1-д “Хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх”, 84.4.2-д “Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 113 дугаар тогтоолоор баталсан төсөв, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн санхүүгийн удирдлагын газрын даргын баталсан “Сургалтын зардлын төсөв”-ийг баримтлаагүй, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын батлагдсан төсвийг сургалтын төлөвлөгөөнд тусгасан зардалд хөрөнгө зарцуулах

3.1.3. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сахилгын шийтгэлтэй ажилтнуудын 2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл цалинг тулган шалгахад тооцооллын алдаа гаргаж, 22 ажилтанд 527.6 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/340 дугаар тушаал “2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл цалин олгох тухай”, 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/82 тоот тушаалаар батлагдсан “Жилийн үр дүнгийн нэмэгдэл цалин олгох журам”-ын 3.4-т “Жилийн үр дүнгийн нэмэгдэл цалинг тооцохдоо тухайн жилийн ажилласан цагийг ажиллавал зохих цагт ногдуулан нэмэгдэл цалинг тооцно”, 3.8-д “Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр тухайлсан ажилтнуудын жилийн үр дүнгийн нэмэгдэл цалинг нэмэгдүүлж, бууруулж болно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үр дүнгийн нэмэгдэл цалинг үнэн зөв тооцоолж, хяналт тавьж ажиллах

3.1.4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь Tender.gov.mn цахим системд тендер сонгон шалгаруулалтын гэрээний үр дүнг бүрэн нийтлээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.2.5-т "Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх", 48.2.7-т "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 46 дугаар зүйлийн 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана" гэж заасантай тус тус нийцээгүй, НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", НББОУС 32 "Санхүүгийн хэрэглүүр, толилуулга", санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.2.5, 48.2.7 дахь заалтуудыг баримталж, тендер сонгон шалгаруулалтын гэрээний үр дүнг бүрэн нийтэлж байх.

3.1.5. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь 2019-2022 онд үүссэн бусад байгууллагаас авах нийт 129,123.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", НББОУС 32 "Санхүүгийн хэрэглүүр, толилуулга", санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6-д заасныг баримталж, дансны авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах

3.1.6. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус компанийн дансны өглөг болон урьдчилж орсон орлого дансанд 2011-2022 онд үүссэн 14 харилцагчийн 1,231,890.9 мянган төгрөгийн насжилт өндөртэй өр төлбөрийг

тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцээгүй, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, НББОУС 32 “Санхүүгийн хэрэглүүр, толилуулга”, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6-д заасныг баримталж, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс (мянган төгрөгөөр)										
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Зөрчлийн товч утга													
Гүйцэтгэх захирлын 2024 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ыг зөрчин 2025 онд 1 удаагийн нөхөн дүүргэлтийн хэмжээг хэтрүүлсэн 4 удаагийн орлогын гүйлгээ байна.	1	115,000.0	-	-	1	115,000.0	-	-	-	-	-	-	-
Тайлант онд сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 14,197.9 мянган төгрөгийн сургалтын зардал гаргасан байна.	1	14,197.9	-	-	1	14,197.9	-	-	-	-	-	-	-
Сахилгын шийтгэлтэй ажилтнуудын 2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл цалинг тулган шалгахад тооцооллын алдаа гаргаж 22 ажилтанд 527.6 мянган төгрөгийг зөрүүтэй олгосон байна.	1	527.6	-	-	1	527.6	-	-	-	-	-	-	-
“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь Tender.gov.mn цахим системд тендер сонгон шалгаруулалтын гэрээний үр дүнг бүрэн нийтлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2019-2022 онд үүссэн бусад байгууллагаас авах нийт 129,123.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	129,123.2	-	-	1	129,123.2	-	-	-	-	-	-	-

“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тус компанийн дансны өглөг болон урьдчилж орсон орлого дансанд 2011-2022 онд үүссэн 14 харилцагчийн 1,231,890.9 мянган төгрөгийн насжилт өндөртэй ер төлбөр тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй байна.	1	1,231,890.9	-	-	-	-	1	1,231,890.9	-	-
Дүн	6	1,490,739.6	-	-	-	-	6	1,490,739.6	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байгаа нь өмнөх оны аудитаар өгсөн “Шилэн дансны цахим системд мэдээллийг үнэн зөв, иж бүрэн зохих хугацаанд нь байршуулах” зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-